



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 10 дугаар сарын 28  
№ 42 (1240)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ  
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

768.	Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 60	3035
769.	Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай	Дугаар 61	3036
770.	Түр хорооны даргыг сонгох тухай	Дугаар 62	3037

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

771.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 134	3038
772.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 135	3038
773.	Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 145	3039

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

774.	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 203	3039
775.	Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 204	3041







## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 10 дугаар сарын 14-ний өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

### Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, зээл олголт, эргэн төлөлтийн явц, байдлыг шалгахаар Монгол Улсын Их Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор байгуулсан Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг 2022 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс зургаан сараар сунгасугай.

2.Энэ тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**Mongolx Folo\_02 Ykhx Hovxg 02 Dooxlgx**

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠯ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠯ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠯ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠯ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠯ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠯ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠯ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠲᠣᠭᠲᠣᠭᠣᠯ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ





## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 134

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 195 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан Дулмаагийн Оюундарийг Дархан-Уул аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 05-ны өдөр

Дугаар 135

Улаанбаатар  
хот

### Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 197 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан Балжирхүүгийн Энхтайваныг Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 07 дугаар  
сарын 08-ны өдөр

Дугаар 145

Улаанбаатар  
хот

### Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1, 36.11 дэх хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 186 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Дэмбэрэлийн Батбаатарыг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилсугай.

2. Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалд томилогдсонтой холбогдуулан Дэмбэрэлийн Батбаатарыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН  
ХҮРЭЛСҮХ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 203

Улаанбаатар  
хот

### Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2, 13.3, 13.4, 14.1, 14.3, 15.2.3, 15.3, 17.1.2, 17.1.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээ авч ажиллахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, эрхлэгч нар тус тус үүрэг болгосугай:

1.1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.1, 5.2-т заасны дагуу тэргүүн дэд, дэд, орлогч даргатай байхыг хориглосон төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтныг ажлаас чөлөөлөх арга хэмжээ авч, тэтгэмжийг зохих журмын дагуу шийдвэрлэх;



1.2. жил бүрийн төсвийн төслийн талаарх саналаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлсний үндсэн дээр хөрөнгө оруулалтын болон урсгал зардлыг төлөвлөж, эрх бүхий этгээдэд хүргүүлэх;

1.3. байгууллагын үндсэн чиг үүрэгт шууд хамаарах, үйл ажиллагааны цар хүрээ, онцлог байдал нь танхимаар болон биечлэн хийх зайлшгүй шаардлага үүсдэгээс бусад тохиолдолд сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулах;

1.4. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3, 13.4 дэх хэсгээр хориглосон хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийг 2022 онд боловсруулахгүй, энэ чиглэлээр төсвөөс хөрөнгө зарцуулахгүй байх.

2. Төрийн албан хаагчийн албан ажлын ерөөний талбайн хэмжээ, дотоод зохион байгуулалт, тавилга, техник хэрэгслийн нийтлэг жишигт өөрчлөлт оруулах санал боловсруулж, 2022 оны 2 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.

3. Төрийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишиг тогтоох талаар санал боловсруулж, 2022 оны 2 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.

4. Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний 2023 оны төлөвлөгөөний төслийг боловсруулж цахим дэлгүүрт оруулах, бараа, үйлчилгээний тоо хэмжээ, гэрээ байгуулсан нэгж үнийн талаарх санал, мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт, цахим дэлгүүрийн үйл ажиллагааг олон нийтэд таниулах, дэлгүүрт байршуулах бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтыг шуурхай, нээлттэй зохион байгуулахыг Төрийн худалдан авах ажиллагааны газар (Х.Улам-Өрнөх)-т үүрэг болгосугай.

5. Үзүүлж байгаа үйлчилгээнийхээ орлогоор өөрийгөө санхүүжүүлэх боломжтой төсвийн байгууллага, улсын төсөвт үйлдвэрийн газрыг аж ахуйн тооцооны зарчмаар ажиллуулах болон төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг судлан санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

6. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдоржид үүрэг болгосугай.



7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 388 дугаар тогтоолын 5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**САНГИЙН САЙД**

**Б.ЖАВХЛАН**

## **МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2022 оны 5 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 204

Улаанбаатар  
хот

### **Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 17.1.2, 17.1.3, Төрийн албаны тухай хуулийн 61.1.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Автомашин хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтнаас бусад албан тушаалтны албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа, төрийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашины талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлж, тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.

2.Энэ тогтоолын 1-д заасны дагуу татан төвлөрүүлсэн төрийн өмчид бүртгэлтэй суудлын автомашиныг “Засгийн газрын автобааз” УТҮГ-т, орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашиныг тухайн аймаг, нийслэлийн харьяа автотээврийн байгууллагад шилжүүлж, төрийн болон орон нутгийн байгууллагын нийтлэг үйлчилгээний хүрээнд дуудлагын автомашины зориулалтаар ашиглуулах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Дуудлагын автомашины зориулалтаар хуваарилан шилжүүлснээ бусад автомашиныг төрийн холбогдох байгууллагын зайлшгүй шаардлага, хэрэгцээг харгалзан эрэмбэлсний үндсэн дээр зарим хэсгийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.5-д заасан байгууллагад албан ажлын зориулалтаар хуваарилах, үлдэх хэсгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулж, орлогыг улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Засгийн газрын автобааз” УТҮГ-ыг өөрчлөн зохион байгуулах, аймаг, нийслэл дэх автотээврийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, тухайн нутаг дэвсгэрийн болон автомашин, замын хөдөлгөөний зураглал, байршлын орон зайн мэдээллийг бүрэн хамруулсан үйлдлийн болон хяналтын шинэ дэвшилтэт техник, технологи, программ хангамж бүхий нэгдсэн системийг төрийн байгууллагын автомашины захиалга, дуудлагын нийтлэг үйлчилгээнд нэвтрүүлэн хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг шуурхай сонгон шалгаруулж хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), Төрийн худалдан авах ажиллагааны газар (Х.Улам-Өрнөх)-т тус тус даалгасугай.

5. Автомашины дуудлага үйлчилгээний нийтлэг журам, үйлчилгээний үнэ тариф, зардлын норм, нормативыг боловсруулж Сангийн сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаар батлуулан мөрдүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.

6. Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автомашинд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар олгох арга хэмжээг 2022 онд багтаан зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгасугай.

7. “Суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтны жагсаалт”-ыг хавсралт ёсоор баталсугай.

8. Энэ тогтоолын хавсралтад заасан суудлын автомашиныг өдрийн 60 км, дуудлага үйлчилгээний автомашиныг өдрийн 40 км-ээс хэтрүүлэхгүйгээр ашиглаж байхаар тогтоосугай.

9. Автомашины хэрэглээг хязгаарласан, автомашин төвлөрүүлэн, шилжүүлсэнтэй холбогдуулан жолооч нарыг үргэлжлүүлэн ажиллуулах, шаардлагатай бол шилжүүлэн байршуулах, ингэхдээ тэдний орлого,



нийгмийн баталгааг одоо байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус даалгасугай.

10.Энэ тогтоолыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг шуурхай удирдлага, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, явц байдлыг шаардлагатай бол Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгасугай.

11.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 184 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

**Ц.НЯМДОРЖ**

Засгийн газрын 2022 оны 204 дүгээр  
тогтоолын хавсралт

**СУУДЛЫН АВТОМАШИН АШИГЛАХ ЭРХ БҮХИЙ  
АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ**

1. Улсын Их Хурлын Дэд дарга
2. Засгийн газрын гишүүн
3. Үндсэн хуулийн цэцийн дарга
4. Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч
5. Улсын ерөнхий прокурор
6. Монголбанкны Ерөнхийлөгч
7. Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга
8. Шүүхийн сахилгын хорооны дарга
9. Ерөнхий аудитор
10. Авлигатай тэмцэх газрын дарга
11. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга
12. Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга
13. Төрийн албаны зөвлөлийн дарга



14. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга
15. Санхүүгийн зохицуулах хорооны дарга
16. Хүний эрхийн үндэсний комиссын дарга
17. Сонгуулийн ерөнхий хорооны дарга
18. Үндэсний статистикийн хорооны дарга
19. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга
20. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга
21. Аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга

---o0o---

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 0.75

**Индекс: 200003**